

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо /цаашид холбоо гэх/-оос гишүүнчлэл, гишүүнчлэлийн ангилал, гишүүний бүртгэл, гишүүний татвартай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. ГИШҮҮН

- 2.1. Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дурын үндсэн дээр элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, хамт олон, бэлчээр ашиглагчдын хэсэг, иргэн байна.
- 2.2. Холбоонд гишүүнчлэлийн татвараа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, бэлчээр ашиглагчдын хэсэг, иргэнийг Холбооны гишүүн; салбар холбоонд гишүүнчлэлийн татвараа төлдөг аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, бэлчээр ашиглагчдын хэсэг, иргэнийг салбар холбооны гишүүн гэнэ.

3. ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНГИЛАЛ

- 3.1. Гишүүд болон шинээр элсэж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн гишүүний ангиллаа өөрөө сонгох бөгөөд дараах ангиллуудтай байна:
- Хүндэт гишүүн
 - Үндсэн гишүүн
 - Дэмжигч гишүүн
 - Оюутан гишүүн
- 3.2. Хүндэт гишүүн Холбооны үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд үлэмж хэмжээний үүрэг гүйцэтгэсэн буюу Холбооны эрх ашгийг тууштай хамгаалагч гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна. Хүндэт гишүүн татвар төлөхгүй байж болно.
- 3.3. Гишүүнчлэлийн ангилал болон жилийн хураамжийг дараах байдлаар зохицуулна.
- 3.4. Үндсэн гишүүн буюу байгууллагын гишүүнчлэл:
- 3.4.1. Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, салбар холбоо – 1 сая төгрөг
- 3.4.2. Бусад байгууллагууд – 200,000 төгрөг
- 3.5. Дэмжигч гишүүн /Иргэн буюу хувь хүн/ – 50,000 төгрөг
- 3.6. Оюутан гишүүн - 20,000 төгрөг

4. ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛ

- 4.1. Холбооны гишүүн болохыг хүсэгч нь холбооны байранд өөрийн биеэр хүрэлцэн ирэх, эсвэл албан ёсны цахим хуудсанд байрлуулсан бүртгэлийн анкетыг бөглөснөөр бүртгэлд хамрагдана
- 4.2. Гишүүний ангиллын дагуу жилийн татварыг холбооны дансаар төлнө. **Дансны дугаар: 5027728932, ХААН банк, МБАНХ**
- 4.3. Гишүүн татвараа төлснөөр Холбооны гишүүнчлэл баталгаажна.
- 4.4. Гишүүний хүсэлтээр Холбооны гишүүнчлэлийн гэрчилгээ олгож болно.
- 4.5. Гишүүний бүртгэл, гишүүнчлэлтэй холбогдох асуудлыг холбооны гүйцэтгэх алба хариуцна.
- 4.6. Гишүүнчлэлийн хугацааг гишүүн татвар төлж эхэлсэн өдрөөс тооцох бөгөөд тухайн өдрөөс 365 хоног байна.
- 4.7. Гишүүний ангиллын дагуу Холбооноос авах үйлчилгээний хүснэгтийг авч, авсан үйлчилгээн дээрээ хяналттай ажиллана.
- 4.8. Холбооны гишүүний хувьд Холбооны үйл ажиллагаанд өөрийн идэвхтэй оролцоогоо бий болгож хамтран ажиллана.
- 4.9. Холбоонд хандсан болон төр, засагт уламжлах аливаа санал хүсэлт, шүүмжлэлээ бичгээр өгнө.

5. ГИШҮҮДИЙН ЕРӨНХИЙ ДАВУУ ТАЛУУД

- 5.1. МБАНХ-ны гишүүн болсноор Гишүүн бүрд бий болох давуу талууд:
 - a. Монголын бэлчээр ашиглалтын орчны талаарх мэдээ, мэдээллийг хамгийн түрүүнд авах мөн түүнд оролцох боломж нээгдэнэ.
 - b. www.greenmongolia.mn веб хуудсанд байрлах гишүүдийн буланд байгууллага болон үйл ажиллагааны мэдээллийг оруулах.
 - c. МБАНХ-ны орон нутаг дахь 21 аймгийн салбар холбоо, хоршоо, сумдын холбоо, хоршоодоор дамжуулан үйл ажиллагаандаа ашигтай харилцаа үүсгэх.
 - d. МБАНХ-ны гадаад улс орнуудтай тогтоосон холбоо харилцааг ашиглан төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой.
 - e. МБАНХ-оос эрхлэн гаргадаг бизнесийн сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл, сонин сэтгүүл, цахим мэдээ зэргийг үнэ төлбөргүй хвлээн авна.
 - f. МБАНХ-ны гишүүдэд үзүүлдэг аливаа хөнгөлөлтүүдийг эдлэх, бизнес саналууд, хамтран ажиллах саналуудыг авах боломжтой.
 - g. МБАНХ-ны вебсайт болон холбооны facebook хуудсаар өөрийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес санал, төрөл бүрийн promotion-уудыг сурталчлуулах боломжоор хангагдана.

- h. МБАНХ-ны гишүүний ангилалтай логог өөрийн вебсайт болон албан бланк, нэрийн хуудсан дээрээ байрлуулах эрхтэй.
 - i. МБАНХ-ны дэргэдэх салбарчилсан Зөвлөлүүдэд орж, үйл ажиллагаа эрхлэхэд учирч буй хvндрэл бэрхшээлээ шийдвэрлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой.
 - j. Бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн чиглэлээр дотоод, гадаадын зөвлөхүүдийг авч ажиллуулах боломжтой.
- 5.2. Холбооны гишүүдэд дараах үйлчилгээний төрлөөр хөнгөлөлт эдлэх буюу үнэгүй үйлчилгээ үзүүлнэ.

Үзүүлэх үйлчилгээ	Гишүүнчлэлийн ангилал			
	Хүндэт гишүүн	Жинхэнэ гишүүн	Дэмжигч гишүүн	Оюутан гишүүн
1. Малчид, малчдын байгууллагын эрх зүйн орчин, бүтэц, тогтолцоо				
Гарын авлага бэлтгэж өгөх	Үнэгүй	50%	50%	50%
Зөвлөгөө өгөх	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй
Урт хугацааны сургалт явуулах	50%	50%	30%	30%
Богино хугацааны сургалт явуулах	50%	50%	30%	30%
Захиалгаар очиж сургалт өгөх	50%	50%	30%	30%
Мэргэжлийн байгууллага, судлаачидтай холбож өгөх	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй
Бэлчээр ашиглагчдын хэсэг, сум, аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, хоршоо байгуулах талаар зөвлөгөө өгөх	50%	50%	30%	30%

Үзүүлэх үйлчилгээ	Гишүүнчлэлийн ангилал			
	Хүндэт гишүүн	Жинхэнэ гишүүн	Дэмжигч гишүүн	Оюутан гишүүн
Гарын авлага бэлтгэж өгөх	Үнэгүй	50%	10%	10%
Зөвлөгөө өгөх	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй
Урт хугацааны сургалт явуулах	50%	50%	30%	30%
Богино хугацааны сургалт явуулах	50%	50%	30%	30%
Захиалгаар очиж сургалт өгөх	50%	50%	30%	30%
Мэргэжлийн байгууллага, судлаачидтай холбож өгөх				
Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах	50%	50%	30%	30%
Бэлчээрийн экологийн чадавх тодорхойлох (Хөрс, ургамлын нарийвчилсан судалгаа хийх)	50%	50%	30%	30%
Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох	50%	50%	30%	30%
Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах	50%	50%	30%	30%
Бэлчээрийн зураглал хийх	50%	50%	30%	30%
Бэлчээрийн газрын үнэлгээ хийх	50%	50%	30%	30%
Бэлчээрийн мониторинг хийх	50%	50%	30%	30%
Бэлчээрийн ачаалал, даац тодорхойлох	50%	50%	30%	30%
Бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгчтэй тэмцэх арга зүй	50%	50%	30%	30%
Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах талаар зөвлөгөө өгөх	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй
3. Хоршоо				
Гарын авлага бэлтгэж өгөх	Үнэгүй	50%	10%	10%
Зөвлөгөө өгөх	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй	Үнэгүй
Урт хугацааны сургалт явуулах	80%	60%	20%	20%
Богино хугацааны сургалт явуулах	50%	50%	30%	30%
Захиалгаар очиж сургалт өгөх	50%	50%	30%	30%
Дотоод аудит	80%	60%	20%	20%
4. Маркетингийн зөвлөгөө	80%	60%	20%	20%
5. Санхүү нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө	80%	60%	20%	20%
6. Дундын сангийн менежмент	50%	50%	30%	30%

6. ГИШҮҮНД ОЛГОХ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- 6.1. Холбооны үйл ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулж, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гишүүний амжилтыг нь үнэлж Төр засгийн шагналд тодорхойлно.
- 6.2. Төр засгийн шагналд тодорхойлох болзлыг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 6.3. Бэлчээрийн менежмент, малчид, малчдын байгууллагын хөгжлийн чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж, холбооны үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан гишүүнд Холбооны шагнал урамшууллыг олгоно.
- 6.4. Холбооны шагналын төрөл болон болзлыг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар